

БАТЛАВ:



"Монголын төмөр зам" ТӨХК
Гүйцэтгэх захирал

Б.ЦЭНГЭЛ



"Ти Ай Би" ХХК
Гүйцэтгэх захирал

Б.ТУШИГСАЙХАН

**ТӨМӨР ЗАМЫН УС/ЗАЙЛУУЛАХ ХООЛОЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2019 оны 06 дугаар
сарын .. -ны өдөр

Дугаар АГГ-19/121114/39

Улаанбаатар
хот

1. Нийтлэг үндэслэл

1.1. Төмөр замын ус зайлуулах хоолойн зураг төсөл боловсруулах ажил гүйцэтгэх гэрээг (цаашид "Гэрээ" гэх)

Нэг талаас: "Монголын төмөр зам" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх),

Нөгөө талаас: "Ти Ай Би" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын ус зайлуулах хоолойн зураг төсөл боловсруулах нийт ажлын 50 хувийг гүйцэтгэж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулах, Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

1.3. Захиалагч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн зураг төсөл боловсруулах ажилтай уялдуулан төмөр замын ус зайлуулах хоолойн зургийн тоо хэмжээг тухай бүр гүйцэтгэгчид гаргаж өгөх бөгөөд энэ гэрээ хавсралт болно.

1.4. Гэрээний 1.3-д заасан хавсралтад ажлын тоо хэмжээ зураг төсөл хийж, улсын экспертизээр батлуулах хугацаа буюу ажлын гүйцэтгэлийн хугацааг тодорхой заах бөгөөд Гүйцэтгэгч нь өгөгдсөн ажлыг зураг төсөл зохиох ажлын даалгавар, стандарт, техникийн нөхцөлийн дагуу заагдсан хугацаанд гүйцэтгэнэ.

1.5. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон түүний хавсралтуудаас бүрдэнэ. Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

2. Гэрээний зүйл

2.1. Энэхүү гэрээний зүйл нь Өмнөговь аймгийн Тавантолгой ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян хүртэлх 414,6 км трассаас Захиалагчаас энэхүү гэрээний 1.3-д заасны дагуу гаргаж өгсөн тоо хэмжээ бүхий төмөр замын ус зайлуулах хоолойн зураг төслийг хууль тогтоомж, стандарт, ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэн холбогдох байгууллагаар батлуулж, барилгын ажил гүйцэтгэхэд бэлэн зураг төсөл бий болгох ажил байна.

3. Баталгаа

3.1. Захиалагч нь гэрээний дагуу ажил гүйцэтгүүлэх захиалга өгөх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай эрхийг эрх бүхий байгууллагаас авсан гэдгийг үүгээр баталж байна.

3.2. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь

гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг үүгээр баталж байна.

3.3. Гүйцэтгэгч нь ажлыг хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг үүгээр баталж байна.

3.4. Талууд энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн тапын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг үүгээр баталж байна.

4. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

4.1. Талууд Гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

4.2. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтална.

5. Гэрээг байгуулсанд тооцох

5.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

5.2. Гэрээг монгол хэлээр гурван хувь үйлдэх ба Гүйцэтгэгч нэг хувийг, Захиалагч хоёр хувийг тус тус хадгалах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

5.3. Талууд гэрээг бүртгүүлэх, батлуулах шаардлагатай тохиолдолд түүнтэй холбоотойгоор холбогдох бүхий л баримт бичиг, мэдээллийг гарган өгч хамтран ажиллана.

6. Гүйцэтгэх ажил, түүний үр дүн

6.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Өмнөговь аймгийн Тавантолгой ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян хүртэлх 414,6 км урт төмөр замын ус зайлуулах хоолойн зураг төслийг хууль тогтоомж, стандарт, захиалагчийн өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэн холбогдох байгууллагаар батлуулж, барилгын ажил гүйцэтгэхэд бэлэн зураг төсөл бий болгох ажил байна.

6.2. Гэрээний 6.1-д заасан ажлыг гүйцэтгэсний үр дүнд Захиалагч Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын ус зайлуулах хоолойны ажлыг гүйцэтгэхэд бэлэн зураг төсөлтэй болсон байна.

6.3. Гүйцэтгэгчийн тайлан, зураг төсөлд холбогдох магадлал, баталгаажуулсан баримтууд нь мөн ажлын үр дүн байна.

6.4. Ажлын гүйцэтгэл нь хууль тогтоомж, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд эрх бүхий төрийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөхийц байна.

6.5. Ажлын үр дүн захиалагчийн өмчид тооцогдоно.

7. Ажил гүйцэтгэх хугацаа

7.1. Энэхүү гэрээ нь 2019 оны 06 дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн 2019 оны .. дугаар сарын .. -ны өдрийг дуустал хүчинтэй байх ба Гүйцэтгэгч гэрээний хүчинтэй хугацаанд багтааж гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дууссан байна.

7.2. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа,

зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг эерчих буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

7.3. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

8. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих

8.1. Ажлын гүйцэтгэлд Захиалагч хяналт тавина.

8.2. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих зорилгоор Захиалагч болон түүний ажилтан нь дараах эрх эдэлнэ:

8.2.1. ажлын явцыг шалгах, дүрс бичлэг болон фото зургаар баримтжуулах;

8.2.2. хөндлөнгийн шинжээч урьж ажиллуулах, дүгнэлт гаргуулах;

8.2.3. шаардлагатай тайлбар, мэдээлэл, баримт бичгийг ажил гүйцэтгэгчээс гаргуулан авах.

8.3. Ажлын гүйцэтгэлийн явцыг шалгаж баталгаажуулахдаа талууд хамтарсан тэмдэглэл үйлдэн, ийнхүү шалгасан эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зуран баталгаажуулна.

8.4. Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанарын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

8.5. Ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр ажил гүйцэтгэх нарийвчилсан хуваарийг гарган мөрдүүлж болно.

8.6. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхдээ захиалагчийг явцын болон үе шатанд хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах ажлыг зохион байгуулна.

9. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

9.1. Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл хууль тогтоомж, захиалагчийн өгсөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүсэн захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

9.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

9.3. Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

10. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

10.1. Талуудын албан ёсны хаяг:

10.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025

Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

16.3. Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

17. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

17.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

17.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

17.3. Саналыг хүлээн авсан тал ажлын 14 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

17.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

18. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

18.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 7 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

18.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг 7 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.

18.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

18.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

18.4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хуваарь болон хугацааг 7 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;

18.4.2. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

18.4.3. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

18.4.4. Давагдашгүй хүчин зүйл 30 ба түүнээс олон хоног үргэлжилсэн бөгөөд ажлыг үргэлжлүүлэх шаардлагагүй гэж үзсэн;

18.4.5. Гүйцэтгэгчийн хуурамч баталгаа бусад бичиг баримтыг гаргаж өгсөн;

18.4.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

18.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

18.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 7 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

18.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

18.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

18.6. Энэ гэрээний 18.4, 18.5-д заасны дагуу нэг талын санаачилгаар Гэрээг цуцлах тохиолдолд Гэрээ цуцлах тухай мэдэгдлийг 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

18.7. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 5 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй

зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

18.8. Гэрээний 18.3 -т заасны дагуу аль нэг Талын санаачилгаар Гэрээг цуцалсан бол буруутай Тал ийнхүү цуцалсантай холбоотой зардал болон нөгөө Талд учирсан хохирлыг нөхөн төлнө.

19. Хариуцлага

19.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

19.2. Энэ гэрээний 18.4-д заасны дагуу гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

19.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

19.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

19.5. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

19.6. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

20. Давагдашгүй хүчин зүйл

20.1. Дайн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист халдлага, хүн малын гоц халдварт өвчний улмаас хөл хорио тогтоосон, байгалийн гамшигт үзэгдэл болох үер, хүчтэй шуурга болсон нь талууд үүрэг гүйцэтгэхэд саад учруулж байгаа, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тухайн нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулна.

20.2. Давагдашгүй хүчин зүйл бий болсон эсэх талаар гэрээний талууд маргасан тохиолдолд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас холбогдох лавлагааг авч маргааныг шийдвэрлэнэ.

20.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас ажил гүйцэтгэх хугацаа болон ажлыг сунгах, түүний төсөвт өртөгт нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү асуудлыг талууд харилцан зөвшилцөх замаар гэрээнд нэмэлт, хавсралтаар оруулж болно.

20.4. Эрх бүхий төрийн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн ажил саатах, түр зогсох тохиолдолд талууд нэн даруй мэдэгдэж тухайн саатсан хоногоор гэрээт ажлыг хойшлуулах талаар талууд харилцан тохиролцоно.

21. Маргаан шийдвэрлэх

21.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

21.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

21.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

22. Гэрээний хавсралт

22.1. Энэхүү гэрээнд дараах хавсралтуудыг хавсаргана. Үүнд:

- | | | |
|---------|-------------|--|
| 22.1.1. | Хавсралт №1 | Зам, Тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан ажлын даалгавар |
| 22.1.1. | Хавсралт №2 | Талуудын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, бусад бичиг баримт |
| 22.1.2. | Хавсралт №3 | Хоолойн тоо хэмжээ, зураг төслийн ажлыг гүйцэтгэх хугацаа |
| 22.1.3. | Хавсралт №4 | Гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх баримт бичиг судалгаа хүлээлгэн өгсөн акт |
| 22.1.4. | Хавсралт №4 | Ажлын үр дүн хүлээлцсэн акт. |

23. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК
Хиймэл байгууламжийн инженер

Б.Төртулга

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Ти Ай Би” ХХК
Зургийн Ерөнхий Инженер


Ч.Намшир

БАТЛАВ.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧИЙН ДАРГА С. БАТБОЛД

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГ ДАХЬ ЗҮҮНБАЯН
ӨРТӨӨНӨӨС ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ
ТАВАНТОЛГОЙ НҮҮРСНИЙ ОРД ХҮРТЭЛХ ТӨМӨР ЗАМЫН ГҮҮР, УС
ӨНГӨРҮҮЛЭХ ХООЛОЙ БАРИХ ИНЖЕНЕРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2019 оны 05-р сарын 09-ны өдөр

Улаанбаатар хот

1. Зураг төсөл, боловсруулах үндэслэл	1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04-р сарын 135 дугаар тогтоол
2. Гүүр, ус өнгөрүүлэх хоолой барих байршил	Өмнөговь аймгийн Цогтцэций, Дорноговь аймгийн Сайншанд сумдын нутаг
3. Төмөр замын шугамын эхлэл	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой нүүрсний ордоос
4. Төмөр замын шугамын төгсгөл	Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь Зүүнбаян өртөө хүртэл
5. Захиалагч	"Монголын төмөр зам" ТӨХК
6. Зураг төслийн гүйцэтгэгч байгууллага	Зохих эрх бүхий дотоодын болон хууль журмын дагуу эрх бүхий нь хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын мэргэжлийн байгууллага, компаниуд
7. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	2019 оны 08 сарын 12 дотор
8. Зураг төсөл төлөвлөлтийн норм, стандарт	1. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, стандарт, норм норматив: 1.1 Монгол Улсын Төмөр замын тээврийн тухай хууль, багц дүрэм, журмууд 1.2 Төмөр замын гүүр хоолойн зураг төсөл боловсруулах тухай норм ТВ 1002.1-2005 1.3 Төмөр замын зурвас газарт тавих шаардлага MNS:2014 1.4 Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ MNS5833:2010 1.5 Бетон зуурмагийн ажилд хэрэглэх элсний найрлага түүнд тавигдах техникийн дугаар шаардлага MNS0392:2014

Хуулбар өгсөн он дугаар
2019 оны 05 сарын 09-ны өдөр

	<p>хийж, гүүр, хоолойн байршил, тоо хэмжээ, хүчин чадлыг тодорхойлох, гүүрийн тооцоот усны урсац, гүүрийн гидравлик параметрууд, хоолойн тооцоот урсцыг тооцох, төмөр зам дагуу гол болон усны зүйн тойм, газар зүйн байдал, геологи болон цаг уурын онцлогийг харгалзан трассын нийт уртын дагуу ус зүйн тооцоог стандартад заагдсаны дагуу хийх.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Геологийн судалгааг үндэслэн гүүрнүүдийн тулгуурын гүн тодорхойлох ❖ Төмөр замыг үерийн уснаас хамгаалах далан шуудууны хэмжээг тогтоох. ❖ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг үндэслэн эко-гүүр (эстакад)-ийн тоо, хэмжээг тогтоох ❖ Гүүр, ус өнгөрүүлэх хоолойн зураг төсөл боловсруулахдаа байр зүйн зураглал, инженер-геологи, геотехник, ус зүйн судалгааны үр дүнг үндэслэл болгох ❖ Ан амьтны шилжилт хөдөлгөөнийг хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх
--	---

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

"МТЗ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал


"МТЗ" ТӨХК-ийн Дэд захирал

"МТЗ" ТӨХК-ийн Инженер, технологийн хэлтсийн дарга

Боловсруулсан:

"МТЗ" ТӨХК-ийн Суурь бүтцийн албаны ахлах инженер

"МТЗ" ТӨХК-ийн Хиймэл байгууламжийн инженер




А.Батболд

Б.Цэнгэд

Р.Батсүх

Д.Нямлхагва



Ж.Энхбаяр

Бүртгэлийн дугаар ... 295 ...
МОНГОЛ УЛСЫН
ХУУЛБАР ҮЙС
 Хуулбар өгсөн ...
 2019 оны 05 сарын 05 өдөр

2019.05.05